



“МОНГОЛ БАЗАЛЫТ” ХК-ийн ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 02-р сарын 08-ны өдөр

№ 01









Улаанбаатар хот

Монгол базальт ХК-ийн 2021 оны бизнес төлөвлөгөөг батлах тухай

“Монгол Базальт” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол Базальт” ХК-ийн 2021 оны Бизнес төлөвлөгөөг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, төлөвлөгөөний талаарх мэдээллийг танилцуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал /А.Энхгэрэл/-д даалгасугай.
3. Бизнес төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороонд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

 /Л.Ариунболд/
 /Г.Ганзориг/
 /А.Энхгэрэл/
 /П.Сайнбилэг/
 /Б.Шаравсамбуу/
..... /Хан Гю Бунг/
 /Ш.Энхтөр/
 /Ч.Зоригтбаатар/
 /Т.Цэнд-Аюуш/



“МОНГОЛ БАЗАЛЫТ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 02-р сарын 08-ны өдөр

№ 02

Улаанбаатар хот

Монгол базальт ХК-ийн 2020 оны
санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлт гаргах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, Компанийн дүрмийн 6-р бүлгийн 6.2, 6.5 дах заалт, “Монгол Базальт” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн тэмдэглэлийг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Монгол Базальт” ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг 2021 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:



..... /Л.Ариунболд/
..... /Г.Ганзориг/
..... /А.Энхгэрэл/
..... /П.Сайнбилэг/
..... /Б.Шаравсамбуу/
..... /Хан Гю Бунг/
..... /Ш.Энхтөр/
..... /Ч.Зоригтбаатар/
..... /Т.Цэнд-Аюуш/



“МОНГОЛ БАЗАЛТ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 02-р сарын 08-ны өдөр

№ 03

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.5, 46.8 дахь заалтууд, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны 02-р сарын 08-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол базальт” ХК-ийн 2020 оны цэвэр ашгийн 100 %-ийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон тараахаар шийдвэрлэж, нэгж хувьцаанд 2.84 төгрөгийн ногдол ашиг хуваарилсугай.
2. Ногдол ашиг авах хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг 2021 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр байхаар тогтоосугай.
3. Хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дэх дансанд 2021 оны 06 сарын 31 өдрөөс өмнө гэрээ байгуулж байршуулахыг Гүйцэтгэх захирал /А.Энхгэрэл/-д зөвшөөрсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



..... /Л.Ариунболд/

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:

..... /Г.Ганзориг/

..... /А.Энхгэрэл/

..... /Н.Сайнбилэг/

..... /Б.Шаравсамбуу/

..... /Хан Гю Бунг/

..... /Ш.Энхтөр/

..... /Ч.Зоригтбаатар/

..... /Т.Цэнд-Аюуш/



“МОНГОЛ БАЗАЛЫТ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 02-р сарын 08-ны өдөр

№.04

Улаанбаатар хот

Зөвшөөрөл олгох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.16 дах заалт, 83 дугаар зүйлийн 83.8 дах заалт, “Монгол Базальт” ХК-ийн дүрмийн 6.9.3.6 дах заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 02-р сарын 08-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. 2020 онд дэлхий нийтэд үүсээд байгаа Ковид-19 цар тахлын улмаас компанийн үйлдвэрлэл борлуулалтын үйл ажиллагаанд үүссэн нөхцөл байдлыг үндэслэн компанийн эргэлтийн хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор ХААН Банкнаас 500,000,000 /таван зуун сая/ төгрөгийн зээл авах их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрлийг ЦД88081664 регистрийн дугаартай Гүйцэтгэх захирлын албан тушаалтай Ариунболдын Энхгэрэлд зөвшөөрсүгэй.
2. Дээр дурьдсан зээлийн барьцаанд 2020 оны 5 дугаар сарын 29 – ний өдрийн №3 тоот ТУЗ – н тогтоолын хүрээнд 2 – т заасан хөрөнгүүдийг давхар барьцаалах болон ЦД88081664 регистертэй Ариунболдын Энхгэрэлийн өмч бүхий У-2203012360 дугаартай Сүхбаатар дүүрэгийн 1 – р хорооны Энхтайваны өргөн чөлөө 10/3 дугаар байрны 6 тоот – д байршилтай 150м.кв талбайтай таван өрөө орон сууц бүхий үл хөдлөх хөрөнгийг нэмж барьцаалуулахыг зөвшөөрсүгэй.
3. Дээр дурьдсан “ХААН Банк”-иас зээл авахад холбогдох гэрээ хэлэлцэлд компанийг төлөөлж гарын үсэг зурах, барьцаалбар үйлдэх, компанийг төлөөлөх эрхийн зөвшөөрлийг ЦД88081664 регистрийн дугаартай Гүйцэтгэх захирлын албан тушаалтай Ариунболдын Энхгэрэлд зөвшөөрсүгэй

ЗӨВШӨӨРСӨН:

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:



..... /Л.Ариунболд/

..... /Г.Ганзориг/

..... /А.Энхгэрэл/

..... /П.Сайнбилэг/

..... /Б.Шаравсамбуу/



BASALTWOOL
МОНГОЛБАЗАЛТ ХК

“МОНГОЛ БАЗАЛТ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

..... /Хан Гю Бунг/

..... /Ш.Энхтөр/

..... /Ч.Зоригтбаатар/

..... /Т.Цэнд-Аюуш/